



НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2018 оны 11 сарын 22 өдөр

Дугаар А/92

Улаанбаатар хот

Зочид буудал, дэн буудлын үйл
ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгох,
хүчингүй болгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь заалт, Аялал жуулчлалын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.1, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2011 оны 120 дугаар тогтоолоор батлагдсан “Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт аялал жуулчлалын байр сууцны үйл ажиллагаа эрхлэх журам”-ын 5.1, Газрын дүрмийн 2.5.3-т заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт аялал жуулчлалын байр сууцны үйл ажиллагаа эрхлэх журам” болон “Зочид буудалд тавигдах ерөнхий шаардлага MNS 4588:2008” стандартын шаардлагыг хангасан, тушаалын нэгдүгээр хавсралтад дурдсан аж ахуйн нэгжид зочид буудлын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг нэг жилийн хугацаатай олгосугай.

2. “Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт аялал жуулчлалын байр сууцны үйл ажиллагаа эрхлэх журам” болон “Дэн буудалд тавигдах ерөнхий шаардлага MNS 5738:2007” стандартын шаардлагыг хангасан, тушаалын хоёрдугаар хавсралтад дурдсан, аж ахуйн нэгжид дэн буудлын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг нэг жилийн хугацаатай олгосугай.

3. Энэ тушаал гарсантай холбогдуулан Номгон гол ХХК-ийн “Мөнх Хустай” зочид буудлын 17/250, Зургаан талт ХХК-ийн “Алим” зочид буудлын 17/275, Нью Пакс Монгол ХХК-ийн “Монголика” зочид буудлын 17/271, Эй Би Эм Эй ХХК-ийн “Аз” зочид буудлын 17/305, Урандрилинг ХХК-ийн “Уранмотел” зочид буудлын 17/270, Норлин очир ХХК-ийн “Орд” дэн буудлын 17/202 тоот гэрчилгээг хүчингүй болсонд тооцсугай.


4. Зөвшөөрөл авсан байгууллага болон иргэдтэй гэрээ байгуулж үр дүнг тооцон ажиллахыг Захиргааны хэлтэс /Д.Ганболд/-т үүрэг болгосугай.

1150500321


5. Энэхүү тушаалыг Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газар, Нийслэлийн Цагдаагийн газар болон дүүргүүдийн Засаг даргын Тамгын газарт хүргүүлэхийг үйлчилгээний байгууллага, стандарт хариуцсан мэргэжилтэн /Х.Содномдэмбэрэл/-д үүрэг болгосугай.

Гэрчилгээний үнэ болох 5000 /таван мянга/ төгрөгийг тухайн байгууллагаас хураан, Төрийн сан банкны 100200051053 тоот дансанд төвлөрүүлэн, зөвшөөрлийн гэрчилгээний бичилт, олголтод байнгын хяналт тавьж ажиллахыг Ахлах нягтлан бодогч /Б.Батцож/-д даалгасугай.

ДАРГА *D. Batm* Д.БАТСҮХ



Нийслэлийн Аялал жуулчлалын
газрын даргын 2018 оны 11
сарын 22 өдрийн А/92 дугаар
тушаалын нэгдүгээр хавсралт




ЗОЧИД БУУДЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ
ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ АЖ АХУЙН НЭГЖИЙН
ЖАГСААЛТ

2018.11.22

Улаанбаатар хот

Д/д	Иргэн, аж ахуйн нэгжийн нэр	Эзэмшигчийн регистрийн дугаар	Оноосон нэр	Байршил
1	Номгон гол ХХК	2084511	Мөнх Хустай	БГД-ийн 4-р хороо, 2-р хороолол, Энхтайваны өргөн чөлөө 68 тоот
2	Зургаан талт ХХК	2610442	Алим	БЗД-ийн 14-р хороо, Энхтайваны өргөн чөлөө, өөрийн байр
3	Нью Пакс Монгол ХХК	5394384	Монголика	ХУД-ийн 12-р хороо, Биокомбинат гудамж 36 тоот
4	Эй Би Эм Эй ХХК	2546876	Аз	ЧД-ийн 3-хороо, Төмөрчний гудамж-3 тоот
5	Урандриллинг ХХК	5177499	Уранмотел	БГД-ийн 5-р хороо, 10-хороолол, Энхтайваны өргөн чөлөө 49/1

Нийслэлийн Аялал жуулчлалын
газрын даргын 2018 оны 11
сарын 22 өдрийн А/92 дугаар
тушаалын хоёрдугаар хавсралт



ДЭН БУУДЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ
ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ АЖ АХУЙН НЭГЖИЙН
ЖАГСААЛТ

2018.11.22

Улаанбаатар хот

Д/ д	Иргэн, аж ахуйн нэгжийн нэр	Эзэмшигчийн регистрийн дугаар	Оноосон нэр	Байршил
1	Норлин очир ХХК	5147964	Орд	БГД-ийн 5-р хороо, 10-р хороолол, Энхтайваны өргөн чөлөө